

ХҮНИЙ ЗАН ТӨЛӨВИЙГ ВЕДИЙН СУДРААС СУДАЛСАН НЬ

Ц. Цогзолмаа
Доктор (Ph.D)

Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Хэрэглээний шинжлэх ухааны сургууль

tsogzolma@must.edu.mn

Хураангуй: Нийгмийн хүн амын сайн сайхан байдал нь хувь хүний бие даан амьдрах чадвараар тодорхойлогдох тул хүн зан төлөвөө мэдсэнээр мэргэжил авъяасаа хөгжүүлэх боломжтойг Ведийн сударт хэрхэн бичсэн байдгыг судалла. Мөн Монгол домчийн сударт долоон хүрдний эрчимийг, Ведийн хүний амьдралын дөрвөн үүрэгийг, Магадлалын онол математик статистикийн венний диаграм, жигнэсэн дундажийг олох аргаар тооцоолж үзлээ. Тэгээд хүн бүрт үндэс хүрдний чадамж ижил байдгыг харуулав.

Түлхүүр үгс: сүнс, үндэс хүрд, хүүхэд

УДИРТГАЛ

Вед гэдэг нь Мэдлэг, Аюур гэдэг нь Амьдрал гэсэн утгатай санскрит үгнүүд юм. Хүн төрөлхтний бүх хэлэнд санскрит үг орсон байдгийг хэл шинжээч эрдэмтэд баталсан юм. Ведийн судар бол 5000 жилийн тэртээ бичигдсэн дэлхийн анхны ном юм. Түүнийг Энэтхэгээс гарал үүсэлтэй гэсэн буруу ойлголт зарим хүмүүст байдаг. Харин Аюурвед бол 3000 гаруй жилийн өмнөөс Энэтхэгт үүссэн эрүүл амьдралын шинжлэх ухаан юм.

Ведийн сударт хүн хүрээлэн буй орчин болон хүмүүстэй яаж зөв харьцах, амьдралын үйлийг яаж зөв үйлдэхийг тодорхойлон бичсэн байдаг ба хүний амьдралын утга учир, зорилго юу вэ гэдгийг тайлбарласан ном билээ. Түүний тайлбаруудыг судлаачийн зүгээс энгийн үгээр товч тайлбарлая.

Сүнс нэг бие махбодиос нөгөө шинэ бие махбодид шилжихийг (reincarnation, reborn) хойд төрөл гэдэг. Хүний төрөлт үхэл дахин давтагдах хүрднээс ангижирч бурханлаг ертөнцдөө буцаж очих зорилготой гэжээ. Тиймээс хүн бүр мэдрэхгүйгээ хянан захирч, таарч тохирох хэмжээгээр зохистой хэрэглээгээ ханган амьдрах сурах явдал нь хүний үүрэг юм.

Нийгэм эдийн засгийн байдалаа хүмүүс цэцэглэн хөгжүүлэхийн тулд хүмүүсийн гүйцэтгэх дараах дөрвөн үүрэгээ

1. Бурханд үйлчлэх: (энэ нь юу гэсэн санаа вэ гэвэл хүний үйлдэл бүр нь Бурхнаас хамааралтай байдаг гэдгийг хүн ойлгох

2. Элбэг дэлбэг амьдрах: хүн гачигдалгүй эд баялагтай байх

3. Ханамж авах: хүн амьдралаас таашаал ханамж авч байх

4. Ангижралыг ухаарах: Бурханлаг ертөнцдөө буцаж очих биелүүлэн амьдрах ёстой гэжээ.

Хүн хүсэл, мэдрэхүйн эрхтэнгүүдийхээ таашаалаа ханган баясган амьдрах нь баясал цэнгэл юм. Харин жинхэнэ аз жаргал биш гэдгийг ухаарч үүргээ гүйцэтгэж байгаа хүн цэцэн мэргэн оюунлаг болж байгааг илтгэнэ. Хүнийн амьдралын зорилго бол нас ахих тусам жинхэнэ аз жаргал болох ангижрал буюу бурханлаг ертөнцдөө буцаж очих гэдгийг ойлгох явдал юм. Дэлхийд дөрвөн төрлийн хүмүүс амьдардаг. Үүнд: 1. Зовлон гамшигт нэрвэгдэгсэд 2. Эд баялгийн хойноос хөөцөлдөгсөд 3. Сониуч зантангууд 4. Үнэмлэхүйн мэдлэгийн хойноос хайгуул хийгсэд гэсэн дөрвөн төрлийн **шударга хүмүүс** дэлхийд амьдардаг гэжээ. Ведий нийгэмд эдгээр дөрвөн үүргээ биелүүлдэг хүмүүс амьдардаг байжээ.

Өөрөөр хэлбэл ямар ч нийгэмд дараах дөрвөн төрлийн хүмүүс байдаг. Үүнд: брахман буюу оюуны ажил эрхэлдэг, кшатриа буюу цэргийн хүмүүс, вайшиа буюу худалдаачид, шудра буюу ажилчид байдаг. Бурханы толгой нь брахман, гар нь кшатриа, гэдэс нь вайшиа, хөл нь шудра төрлийн хүмүүсээр төлөөлүүлдэг.

Тэгвэл одоогийн нийгмийн бүх ажил мэргэжлийг дөрвөн төрөлд хувааж болно. Жишээлбэл:

1. Эмч, сувилагч, асрагч, инженер, уурхайчин, малчин, үйлдвэрийн ажилчин, тамирчин гэх мэт мэргэжлүүд нь шудра
2. Бизнес эрхлэгч, фермер, компани захирал, худалдаачин, зуучлагч, хөрөнгийг биржийн ажилтан гэх мэт нь вайшиа
3. Төр захиргааны түшмэл, хуульч, цагдаа, шүүгч, цэргийн дарга гэх мэт нь кшатриа,
4. Багш, цэцэрлэгийн багш, номлогч, иогч, бясалгагч гэх мэт нь брахманд харьяалагдана

Өнөө үед эдгээр дөрвөн төрлийн хүмүүсийг кастийн систем эсвэл ангилан ялгаварлал, шатлан захирах ёс гэх мэт гуйвуулсан ойлголтоор тайбарласан байдаг нь хүмүүсийг төөрөгдөлд оруулах санаатай буруу мэдээлэл юм.

Орчин үеийн нийгэм-эдийн засагт зохиомол хуурмаг хэрэгцээг бий болгож байдаг ба ашиг хонжоо олох сонирхолоор бүтээгдэхүүнээ өнгө үзэмж, чанар сайтай гэж сурталчилан хортой нөлөөг нь нуудаг явдал түгээмэл байна. Хүн амьдралаас бие махбодын таашаал ханамж эдлэх, тогтворгүй зан төлөвтэй болгох элдэв хов жив, муу мэдээлэлд анхаарлыг нь хандуулах нэвтрүүлэг хэвлэл мэдээлэээр цацаж байдаг. Тэгвэл үүнээс ангид байхын тулд хүн аливаа үйлдлээ чин сэтгэлээсээ Бурханд үйлчилж байгаа байдалтайгаар хийж гүйцэтгэсэнээр амьдралын зөв хэв маягтай болно.


Нийгмийг олон янзаар тодорхойлдог түүнийг чөлөөт нэвтэрхий толь — Википедиагаас харвал ерөнхий тодорхойлолт нь: **Нийгэм** гэдэг нь өргөн

утгаараа хүмүүсийн зохион байгуулалттай, чиг зорилготой харилцаа, үйл ажиллагаа ба тэдгээрийн үр дүнд бий болсон үнэт зүйлсийн нэгдэл, өөрийгөө байнга нөхөн сэргээж байдаг бие даасан тогтолцооны нийлбэр юм.

Эндээс хархад одоогийн нийгэмд хүн өөрийгөө ямар төрлийн хүн бэ гэдгээ сайн мэдэхгүй барьцалдан нөхцөлдсөн байдлаар үүргээ биелүүлэхээр амьдарч байгаа хүмүүсийн бүрдэл болжээ.

ОНОЛ, СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Хүний зан төлөвийг тодорхойлохдоо магадлалын онол математик статистикийн шинжлэх ухааны олонлогийн хамаарлыг харуулах венний диаграмм болон жинлэсэн дунжийг олох аргаар тооцоолъё.



Энд хүний дөрвөн эрхтний чадамжийг төлөөлсөн толгойг Удирдах, гарыг Шүүх, гэдсийг Солилцох, хөлийг Хөдлөх үйлдлээр төлөөлүүлье. Олонлог тус бүр нь чадваргүйг 0 утга, чадвартайг 1 утгаар тэмдэглэсэн 18 элементтэй A B C D гэсэн олонлогуудыг харгалзан У, Ш, С, Х үсгээр тэмдэглэе. Тэгвэл дөрвөн олонлогийн элементүүдийн харилцан хамаарлыг долоон дэд бүлэгт хуваадаг тэдгээрийг хүний долоон хүрдэнд харгалзуулъя. Тэгвэл тооцоог 1-р томъёогоор нь 1-р хүснэгтэд харуулав.

$$\bar{X} = \frac{x_1 n_1 + x_2 n_2 + \dots + x_k n_k}{n_1 + n_2 + \dots + n_k} = \frac{1}{n} \sum_{i=1}^k x_i n_i$$

1-р томъёо. Жинлэсэн дундаж.

		УДИРДАХ				ШҮҮХ				СОЛИЛЦОХ				ХӨДЛӨХ			
		У1	Ш2	С3	Х4	У1	Ш2	С3	Х4	У1	Ш2	С3	Х4	У1	Ш2	С3	Х4
Х Ү Р Д	7	1	0	0	0	7	0	1	0	7	0	0	0	7	0	0	0
	6	1	1	0	0	6	1	1	0	6	0	1	1	6	1	0	0
	5	1	0	0	0	5	0	1	1	5	0	0	1	5	0	0	1
	4	1	1	1	0	4	1	1	1	4	0	1	1	4	1	0	1
	3	1	1	1	1	3	1	1	1	3	1	1	1	3	1	1	0
2	1	0	1	1	2	0	1	1	2	1	0	1	2	0	1	1	1
1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
Жинлэсэн дундаж		53.6	25	12.5	5.4	10.7	53.6	12.5	25	10.7	5.4	53.6	5.4	12.5	25	10.7	25
Утга		46.4	0	12.5	19.6	14.3	46.4	12.5	0	14.3	19.6	46.4	19.6	12.5	0	14.3	0
Тоо		100	25	25	25	25	100	25	25	25	25	100	25	25	25	25	25

1-р хүснэгт

Хүн төрөхөөсөө удирдах, шүүх, солилцох, хөдлөх дөрвөн шинж чанарын чадварууд нь долоон хүрдэндээ нөөцлөгдсөн байгаа харуулав.

Хүүхдийг 1-3 настай байхад нь ямар зан төлөвтэй болохыг нь сайн ажиглах хэрэгтэй. Дөрвөн төрлийн хүмүүсийн ажил мэргэжилтэй холбоотой хүүхдийн тоглоомон ном, үзэг, буу, сэлэм, мөнгөний гахай, сампин, машин,

эвлүүлдэг байшин гэх мэт тоглоомтой өрөөнд хүүхдээ тоглуулна. Тэгээд хүүхэд өөрийн сүнсний далд ухамсраараа аль нэг тоглоомыг сонгож байнга тоглоод байх нь ажиглагдана. Жишээ нь хүүхэд машинаар тоглоод байвал ажилчин зан төлөвийн хүн гэдэг нь тодорхой болно. Тиймээс түүний сайн инженер эсвэл тамирчин болгох чадамжийг нь хөгжүүлэн хүмүүжүүлэх хэрэгтэй. Түүний хөдлөх чадварын потенциал энерги буюу чадамж 25% гэдэг нь бүх долоон хүрдэндээ жигд чадвартай байгааг харуулж байна. Мөн үнэнч шударга чанарыг төлөвшүүлэхэд анхаарах хэрэгтэй.

1-р хүснэгтэд гарсан үр дүн нь үндэс хүрд нь хүн бүрд ижил байгаа харуулж байна. Хэрэв хүн бүс нутагтаа эзэн сууж, зөв дадал, зөв амьдралын хэвшилтэй, жамаа дагаж байвал осол бэртэл орохгүй л бол өөрөөр өвдөх шалтгаан байхгүй гэж Домчийн судар номонд бичсэнийг батлан харууллаа. Хүрдний эрчим сулрах олон шалтгаан байдаг боловч гол шалтгаан нь 1. Үндэс хүрд гэмтэх нь газраас хөндий амьдрах, 2. үржихүйн хүрд цахилгаан соронзон орон үүсгэгч компьютер, зурагт, интернет сүлжээний долгион цацагч вайфай төхөөрөмжийн дунд байх, 3. наран сүлжээ хүрд нь хүн нар үзэхгүй байх, 4. зүрхэн хүрд нь агаарын урсгалгүй газар байх, 5. хоолойн хүрд нь хүмүүстэй харилцахгүй байх, 6. мэлмийн хүрд нь олон эрээлжилсэн зүйлийн дунд байх, 7. оройн хүрд нь хүн уншиж судлахгүй, од үзэхгүй амьдрах зэрэгт ихээр гэмтдэг байна.

Тэгвэл хүн эдгээрийн гол сөрөг шалтгаанаас урьдчилан сэргийлэх хэрэгтэй ба дараах дөрвөн төрлийн хүн нь

1. Сурах судлах сонирхолтой, эрдэм мэдлэгтэй хүмүүс юм. Бусдад мэдлэг хүртээх хүсэлтэй, хүүхэд байхаасаа үнэнд хүрэхийг эрмэлзэн ямар нэгэн зүйлийг судлан шинжлэхийг хүсдэг байна зан чанартай байдаг. Гол онцлог нь үнэнч шударга байдаг.
2. Хууль баримтлах, удирдлага доор ажиллах, хэн нэгнийг хамгаалах, дүрэм журам сахиулах үйлд дур сонирхолтой хүмүүс. Гол онцлог нь энэрэнгүй болон шударга ёсны төлөө тэмүүлж байдаг.
3. Худалдаа арилжаа болон аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх авъяас сонирхолтой хүмүүс. Гол шинж нь өглөгч, өгөөмөр, ажил хэрэгч байхын зэрэгцээ баян байх хүсэлтэй байдаг. Хүүхэд байхаасаа ямар нэг зүйл цуглуулах, ямар нэгэн үйл хэрэгт дээгүүр байранд байх, олз ашигтай байхыг эрмэлздэг.
4. Урлах, дархлах ямар нэг тодорхой бодитой бүтээл хийх, бүхнийг өөрийн гараар хийхийг хүсдэг. Онцлог шинж нь ажил хөдөлмөрт дуртай байх явдал юм.

гэдгээ мэдэж өөрийгөө төлөвшүүлэх хэрэгтэй.

ДҮГНЭЛТ

Ведийн судар, Буддын сургааль, Христийн Библи номлолыг судалж үзээд дараах дүгнэлт хийлээ. Хүн *энэрэл, нигүүлсэл, тэвчил, хатуужил, цэвэр ариун, үнэнч шударга* байх зан төлөвийн чанаруудаа

1. Амьдралын хэвшил дадал болгох үйлдэл хийлгэснээр Буддизм нь хүний бие даасан байдлыг үгүй хийж олонх хүмүүсийг хүлцэнгүй хүн болгодог.

2. Итгэл бишрэлээр дадал болгох үйлдэл хийлгэснээр Загалмайтаны хүнийг бие даасан байдалтай болгож олонх хүмүүсийг түрэмгийлэгч хүн болгодог.

3. Эдгээр шинж чанарыг дадуулах биш харин өөрийн заяагдмал онцлог шинж чанараа хөгжүүлснээр 1. мэдлэгтэй, 2. бие даасан, 3. аз жаргалтай, 4. сүнслэг мөн чанартай олонх хүмүүс Бурханлаг хүн болно гэдгийг Ведэд сургажээ.

4. Ямар ч номлолыг судлахгүй бол хүн адгууслаг амьдралтай байх болно.

НОМЗҮЙ

[1] Бхагавад Гита анх айлдсан байдлаараа, Ведийн судар, хуудас 880

[2] Мьягмарсүрэн Д. ба бусад. Монгол домчийн судар, УБ., 2019 он, хуудас 794